



Баримт бичгийн нэр: Инженерчлэлийн салбарын багш, оюутнууд,
Стандарт хэмжил зүйн ажилтан ажиллагсадын
Эрдэм шинжилгээний бага хурлын удирдамж

Баримт бичгийн код: DaTS-ING-GSC

Боловруулсан огноо: 2022.09.15

Өөрчилсөн огноо: 2022.09.20

“БАЙГУУЛЛАГА ДАХЬ БҮТЭЭМЖИЙН ОРЧИН ҮЕИЙН ЧИГ ХАНДЛАГА”

ДЭЛХИЙН ЧАНАРЫН 7 ХОНОГ -2022

Хойд бүсийн эрдэм шинжилгээний бага хурлын удирдамж

	Боловруулсан	Хянасан	Баталсан		
Албан тушаал	Салбарын дэд профессор, доктор (Ph.D)	Салбарын эрхлэгч, дэд профессор, доктор (Ph.D)	ЭНБД дэд профессор, доктор (Ph.D)	Захирал дэд профессор, доктор (Ph.D)	Стандарт хэмжил зүйн хэлтсийн дарга
Овог нэр	Я.Батцэцэг	Ч.Ганзориг	Д.Баясгалан	Ц.Батбаатар	Б.Цэвээндорж
Гарын үсэг					
Огноо	2022.09.20				

Хурлыг зохион байгуулах комисс:

Комиссийн дарга: Б.Цэвээндорж / СХЗХ-ийн дарга/

Комиссийн гишүүд:

Я.Батцэцэг
С.Галбадрах
С.Хүрэлчимэг
С.Алтанцоож
А.Ундрах
Л.Отгончимэг

Д.Эрдэнэчулуун
Б.Хурбаяр
Б.Баярбаатар
Д.Болортуяа
Д.Нарантуяа
С.Болор-Эрдэнэ

АГУУЛГА

НЭГ	Үндэслэл.....	3
ХОЁР.	Зорилго.....	4
ГУРАВ.	Оролцогчдын хамрах хүрээ.....	4
ДӨРӨВ.	Сэдвийн хамрах хүрээ.....	4
ТАВ.	Хурлын албан ёсны хэл.....	4
ЗУРГАА.	Хурлын зохион байгуулалт.....	4
ДОЛОО.	1-р шат: Эрдэм шинжилгээний товч хураангуйд (Абстракт) тавигдах шаардлага.....	5
НАЙМ.	Илтгэлд тавигдах шаардлага.....	5
ЕС.	Эрдэм шинжилгээний өгүүлэлд тавигдах шаардлага.....	5
АРАВ.	Шагнал урамшуулал.....	6
АРВАН НЭГ.	Хураамж.....	6
АРВАН ХОЁР.	Хурлын дэг.....	6
АРВАН ГУРАВ.	Хурал зохион байгуулагдах газрын хаяг.....	6

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Монгол улсын засгийн газрын шинэ сэргэлтийн бодлого нь үндэсний эдийн засгийн өрсөлдөх чадвартай уялдуулан бүтээмжийг дээшлүүлэх стратегийг үндэсний хэмжээнд төдийгүй бүсчилсэн хөгжлийн бодлоготой уялдуулан тодорхой нэг үйлдвэр, аж ахуйн нэгжийн хувьд өрсөлдөөнт зах зээл дээр оршин тогтнох, өрсөлдөх чадвартай байх үндсэн нөхцөл болж байна.

Байгууллага, аж ахуйн нэгж бүр бүтээмжээ дээшлүүлснээр илүү их нэмэгдсэн өртгийг бий болгох ба нийгмийн баялгийг бүтээхэд ихээхэн хувь нэмэр оруулж, улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийг хурдасгахад тодорхой нөлөө үзүүлж аж ахуйн нэгж бүр бүтээмжээ дээшлүүлэх, тэдгээрийг зөв зохистой удирдах бүтээмжийн болон үйлдвэрлэл үйл ажиллагааны нэгдсэн менежментийг шинэ сэргэлтийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлэх гарц шийдлийг олох боломжтой юм.

Үйлдвэрлэл үйлчилгээний газрын чанар стандарт удирдлага ихээхэн байр суурь эзэлж байгаа нь үйлчилгээний газрын бүх нийтийн чанарын төлөө хариуцлагыг дээшлүүлэх өөрсдийн шударга орчныг бүрдүүлэх нь үйлчилгээний байгууллагын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх суурь бодлогыг гадаад дотоодын эрдэмтэдийн бүтээлүүд тодорхойлж байна.

Бизнесийн амжилт нь чанар, инноваци, тогтвортой байдлаас хамаардаг дэлхийн эдийн засагт “Дэлхийн чанарын өдөр”-өөр байгууллагын үндэс суурь болгон бэхжүүлж, чанарын ач холбогдлыг анхаарч үзэх боломжтой юм. Бүтээмж бол үйлчлүүлэгчид үзүүлж буй бүтээгдэхүүн, үйлчилгээ, хүн байгаль харилцан шүтэлцээтэй оршин тогтнодог зарчимд тулгуурлан эко системийн нөхөн төлжих хүчин чадалд нийцүүлэн шаардлагатай хэрэгцээгээ хангах, чанартай амьдралын нөхцөлийг бүрдүүлэх замаар тогтвортой хөгжилд хүрэх боломжтой хэмээн эрдэмтэд үзэж байна. Энэ үүднээс бидний зохион байгуулж буй эрдэм шинжилгээний бага хурлын үр дүнд орон нутагт сурч, ажиллаж буй залуучууд, эх орон, орон нутагт оруулах бодит өөрчлөлт, амьдралд хэрэгжүүлж болохуйц уламжлал шинэчлэлийг хослуулсан орчин үеийн дэвшилтэт технологийн шийдлийг эрэлхийлсэн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулахуйц судалгаа шинжилгээний бүтээлүүдийг шалгаруулахад чиглэнэ.

ХОЁР. ЗОРИЛГО

Байгууллага аж ахуйн нэгжүүдийн бүтээмжийн тэргүүн туршлагатай танилцах, бүтээмжийн хөдөлгөөнийг өрнүүлэн төлөвшсөн тасралтгүй сайжруулалтын тэргүүн туршлага зэрэг орчин үеийн соёлын чиг хандлага, өсөлт, хөгжил цэцэглэлтийг дэмжихэд оршино.

ГУРАВ. ОРОЛЦОГЧДЫН ХАМРАХ ХҮРЭЭ

Хойд бүсийн орон нутгийн засаг захиргаа, үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллага, орон нутагт жижиг дунд үйлдвэрлэл эрхэлж буй үйлдвэрлэгч, хэрэглэгч, их дээд, мэргэжлийн сургуульд суралцаж буй оюутан, багш эрдэмтэн, судлаачид оролцох боломжтой.

ДӨРӨВ. СЭДВИЙН ХАМРАХ ХҮРЭЭ

Эрдэм шинжилгээ судалгааны ажил нь Монгол улсад болон орон нутагт хэрэгжүүлж болохуйц судалгааны ажил байх бөгөөд дараах үндсэн агуулгыг хамарна. Үүнд:

1. Төрийн бүтээмжийн сэргэлтийн бодлого;
2. Бүтээмжийн менежментийн онол арга зүй, олон улсын чиг хандлага;
3. Үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагуудын бүтээмж дээшлүүлэх боломж;
4. Бүтээмжийн хэмжилт-шинжилгээ-үнэлгээний асуудал;
5. Бүтээмж дээшлүүлэх стратеги чиг хандлага;
6. Ногоон бүтээмж, ногоон инноваци;
7. Бүтээмж ба инновацийн менежмент;
8. Чанарын тууш удирдлага;
9. Хувь хүний хандлага, бүтээмжийн уялдаа;

10. Бүтээмжийн хувьсал;
11. Е бүтээмж;
12. Бүтээмж ба Хүний нөөцийн удирдлага (Hybrid working);
13. Дижитал бүтээмж;
14. Эрсдэл ба бүтээмж.

ТАВ. ХУРЛЫН АЛБАН ЁСНЫ ХЭЛ

Хурлыг монгол дээр зохион байгуулах (илтгэлийг англи орос хэл дээр хэлэлцүүлж болно).

ЗУРГАА. ХУРЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Эрдэм шинжилгээний хурал 3 үе шаттай цахим болон танхимийн хосолсон хэлбэрээр зохион байгуулагдана. Эцсийн шатанд эрдэм шинжилгээний өгүүлэл хэлбэрээр бүрэн эхээр нь хүлээн авч олон нийтэд цахим болон бичгээр танилцуулах ажлыг зохион байгуулна. Шалгаруулалтыг мэргэжлийн, хөндлөнгийн шүүгчдийн бүрэлдэхүүнтэй зохион байгуулна.

№	Хурлын зохион байгуулалтын үе шатууд	Зохион байгуулалтын хугацаа
I үе шат. Судалгааны ажлын товч хураангуйг бичгээр хүлээн авч шалгуур хангасан оюутнуудын 6, судлаач нарын 6 буюу нийт 12 судалгааны ажлын шалгаруулна. Судалгааны ажлын товч хураангуйг 2022 оны 10 сарын 25-ны өдрийн 23:59 цаг хүртэл erdenechuluun@stda.edu.mn , battsetseg.va@stda.edu.mn хаягаар хүлээн авна.		
1	ЭШ-ний өгүүллийн хураангуйг илгээх	2022.10.25
II үе шат: Эхний шатанд шалгарсан оюутнуудын 6, судлаач нарын 6 буюу нийт 12 судалгааны ажлын илтгэлийг олон нийтэд танилцуулж шилдэг тус бүр 3 байрыг тодруулна. 2022 оны 11 сарын 4-нд 10:00-18:00 цагт ШУТИС, ДаТС-ийн хурлын зааланд зохион байгуулагдана.		
2	Эрдэм шинжилгээ судалгааны ажлын бүрэн хэмжээний өгүүллийг авах	2022.10.28
3	Хурал зохион байгуулах өдөр	2022.11.04
III үе шат: 2022 оны 10 сарын 30-ны өдөр 23:59 цаг хүртэл хоёрдугаар шатанд шилдгээр шалгарсан 12 судалгааны ажлын эрдэм шинжилгээний бүрэн хэмжээний өгүүллийг бичгээр хүлээн авна.		
4	Хурлын эмхэтгэл хүлээн авах, цахим болон ном хэлбэрээр тараах үйл ажиллагааг зохион байгуулах.	2022.11.20-30

ДОЛОО.

1-Р ШАТ: ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРААНГУЙ (АБСТРАКТ)-Д ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 1.1. Хурлын хамрах хүрээ, ерөнхий зорилгод нийцсэн сэдэвтэй байх;
- 1.2. Бодит судалгаанд үндэслэсэн байх;
- 1.3. Судалгааны ажлын хураангуй нь судалгааны гол утга санааг илэрхийлсэн байх;
- 1.4. Шинэлэг санаа дэвшүүлсэн байх;
- 1.5. Бодит төсөл хэрэгжүүлэх боломжтой байх;
- 1.6. Үг үсгийн болон утга найруулгын алдаагүй байх.

НАЙМ.

2-Р ШАТ: ИЛТГЭЛ ТАВИГДАХ ШААРДЛАГА

- 8.1. Өгүүлэл бичих загвар файлыг <http://www.stda.edu.mn> / вэб сайтаар орж авах;
- 8.2. Илтгэлийн эхийг монгол хэл дээр дүрэм болон найруулга зүйн алдаагүй бичсэн байх ба ишлэл, зүүлт стандартын дагуу байх;
- 8.3. Судалгааны ажлын сэдэв, илтгэгчийн овог, нэр, албан тушаал, харилцах утас, цахим шуудангийн хаягийг тодорхой бичсэн нүүр хуудастай байх;

- 8.4. Илтгэл нь үндсэн агуулгын хүрээнд үндэслэсэн, шинэлэг, шүүмж, өрнүүлсэн, дүгнэлт, санал дэвшүүлсэн байх;
- 8.5. Зохиогчийн эрх, мэдээллийн аюулгүй байдлыг зөрчөөгүй байх;
- 8.6. Үсгийн фонт Times New Roman 24 хэмжээнээс багагүй байх;
- 8.7. Илтгэлийг power point болон keynote программын аль нэгийг ашиглах;
- 8.8. Илтгэл хэлэлцүүлэх хугацаа 10 минут, асуулт хариулт 5 минут.

ЕС. ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЭЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

1. Товч хураангуй (Абстракт)

Хураангуй нь тухайн өгүүлэлд орсон судалгааны ажлын шинэлэг тал, ач холбогдол, арга зүй, үр дүнг товчлон 250 үгэнд багтааж монгол, англи хос хэлээр бичнэ

2. Оршил

Судалгааны ажлын хэрэгцээ, шаардлага, зорилго, зорилтын талаар дэлгэрэнгүй өгүүлэхээс гадна тухайн асуудал өмнө нь хэрхэн судлагдсан талаар товч дурдана.

3. Судалгааны арга зүй, боловсруулалт

Судалгааны арга зүй, боловсруулалт гэсэн хэсэгт судалгаа хийхэд ашигласан арга зүй, онолыг багтаасан байна. Мөн туршилт хийсэн судалгаа шинжилгээний талаар дэлгэрэнгүй өгүүлнэ. Мөн материал боловсруулсан аргачлалыг заавал бичсэн байна.

4. Судалгааны үр дүн

Судалгаанд ямар үр дүн гарсан, уг үр дүн нь бусад судлаачдынхаас юугаараа шинэлэг бөгөөд ялгаатай болохыг зөвхөн тухайн сэдвийн хүрээнд харьцуулан дэлгэрэнгүй өгүүлсэн байна.

5. Хэлэлцүүлэг

Тухайн судалгааны талаар өдгөө хийгдэж буй болон цаашид хийгдэх шаардлагатай ажлын тухай тусгана. Судалгааны ажлын үр дүнд гарсан урьдчилсан дүгнэлтүүдийг хэрхэн сайжруулах тухай дурдаж, сэдвийн хүрээнд бусад судлаачдын хэрэгжүүлсэн судалгааны үр дүнтэй харьцуулалт хийж, тайлбарлан бичнэ.

6. Дүгнэлт

Судалгааны ажлын үр дүн, тэдгээрийн онол арга зүй, практик ач холбогдол, цаашид хөгжүүлэх боломж зэргийг тусгана.

7. Ашигласан ном хэвлэл

Зөвхөн тухайн судалгаа, өгүүлэлтэй холбогдох бүтээлүүдийг үнэн бодитоор жагсаалтад оруулах бөгөөд заавал ишлэл хийсэн байна.

8. Өгүүлэл бичих формат:

Times New Roman 10, мөр хоорондын зай 1.5, нийт үгийн тоо 5000-6000

АРАВ. ШАГНАЛ УРАМШУУЛАЛ

Судлаач	
Тэргүүн байр	Өргөмжлөл, мөнгөн шагнал, дурсгалын зүйл
Дэд байр	Өргөмжлөл, мөнгөн шагнал, дурсгалын зүйл
Гутгаар байр	Өргөмжлөл, мөнгөн шагнал, дурсгалын зүйл
Оюутан	
Тэргүүн байр	Өргөмжлөл, мөнгөн шагнал, дурсгалын зүйл
Дэд байр	Өргөмжлөл, мөнгөн шагнал, дурсгалын зүйл
Гутгаар байр	Өргөмжлөл, мөнгөн шагнал, дурсгалын зүйл

АРВАН НЭГ. ХУРААМЖ

11.1. Эрдэм шинжилгээ онол практикийн хуралд оролцоход үнэ төлбөргүй, өгүүлэл хэвлүүлэхд 20000 төгрөг

АРВАН ХОЁР. ХУРЛЫН ДҮРЭМ

12.1. Дархан хот, ШУТИС, ДаТС дээр баримталж дүрэм, журмыг чанд баримтлах;

12.2. Зөвхөн урьдчилан бүртгүүлсэн зочид оролцно.

АРВАН ГУРАВ. ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ ГАЗРЫН ХАЯГ

Дархан хот, Цагаан чулуут-5, ШУТИС, ДаТС-ийн хурлын зааланд

Эрдэм шинжилгээний хурлын зохион байгуулалттай холбоотой асуулт байвал доорх хаягийн дагуу холбогдоно уу?

Е-mail хаяг: erdenechuluun@stda.edu.mn

[bolortuya @masm.da.gov.mn](mailto:bolortuya@masm.da.gov.mn)

Утас:

Д.Эрдэнэчулуун /99079208/,

Я.Батцэцэг /99375171/

ыWeb сайт: <http://www.stda.edu.mn/> darkhan@masm.gov.mn